



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

“Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, Даатгалын тухай хуулийн 14.2.17, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5, УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3-д заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг” тогтоох тухай Хорооны 2007 оны 135 дугаар тогтоол, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай Хорооны 2008 оны 64 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар (С.Ганболд)-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Н.Удаанжаргал)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

**Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн
оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний
хөлсний хэмжээг тогтоох журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын тухай хуулийн 14.2.17, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5-д заасны дагуу Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооход энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Жил бүр төвлөрүүлэх

2.1. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн оны 3 дугаар сарын 1-ний дотор Хорооны дансанд төвлөрүүлнэ.

2.2. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компаниас жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өмнөх оны даатгалын цэвэр хураамжийн орлого болон давхар даатгалд төлсөн хураамжаас дараах хувиар тооцно. Үүнд:

2.2.1. Даатгалын цэвэр хураамжийн орлого 3 тэрбум төгрөг хүртэл бол 0.65 хувиар;

2.2.2. Даатгалын цэвэр хураамжийн орлого 3 тэрбум төгрөг буюу түүнээс дээш бол 0.55 хувиар;

2.2.3. Давхар даатгалд төлсөн хураамжаас 0.3 хувиар.

2.3. Энэхүү журмын 2.2-г заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ 3.0 сая төгрөгөөс бага байвал тухайн даатгалын компаниас тухайн онд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 3.0 сая төгрөгөөр тооцно.

2.4. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компаниас жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс 5.0 сая төгрөг байна.

2.5. Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компанийн жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс 5.0 сая төгрөг байна.

2.6. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авч байгаа бол тухайн онд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс нь ердийн даатгалын компанид 3.0 сая төгрөг, урт хугацааны болон давхар даатгалын компанид 5.0 сая төгрөг байна.

2.7. Гадаадын даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Хорооны тогтоолоор шийдвэрлэнэ.

2.8. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно:

2.8.1. Даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс:

	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/
1	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	
	1.1. Улаанбаатар хот	20000
	1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	10000
2	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	
	1.1. Улаанбаатар хот	300000
	1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	150000

2.8.2. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өмнөх оны даатгалын хохирол үнэлгээний хураамжийн орлогоос 0.55 хувиар тооцно.

2.8.3. Энэхүү журмын 2.8.2-т заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ 300000 /гурван зуун мянган/ төгрөгөөс бага байвал тухайн даатгалын хохирол үнэлэгч компаниас тухайн онд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 300000 /гурван зуун мянган/ төгрөгөөр тооцно.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.9. Улаанбаатар хотоос бусад орон нутагт байгуулагдсан боловч салбараа Улаанбаатар хотод нээн үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Улаанбаатар хотод байршилтай даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн жишгээр тогтооно.

Гурав. Тухай бүр төвлөрүүлэх

3.1. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухай бүр Хорооны дансанд төвлөрүүлнэ.

3.2. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ:

д/д	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх зохицуулалтын
-----	----------------------------------	---------------------------

	үйлчилгээний хэмжээ /төгрөгөөр/
Ердийн даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл	
1.1. Улаанбаатар хот	200000
1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	20000
Дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах	100000
Нэр өөрчлөх	
3.1 Компанийн оноосон нэр	2000000
3.2 Салбарын нэр	500000
Даатгагч өөрийн мэдээллийг Хорооны архиваас хуулбарлан нөхөн авах	3000 (нэг хуудас)
Үрэгдүүлж, гэмтээсэн гэрчилгээг нөхөн олгох	200000
Хуулинд заасан бусад үйлчилгээ үзүүлэх	Хорооны тогтоолоор тухай бүр Шийдвэрлэх

3.3. Гадаадын даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа байгуулах зөвшөөрөл олгоход тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Хорооны тогтоолоор тухай бүр шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд, бүрэн төвлөрүүлээгүй хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----000-----